



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: УВА-2022/25/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Увс аймгийн Улаангом сум 2022 он</p>	<p>Цахим хуудас: uvs@audit.gov.mn Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317 Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн “Увс Финанс аудит” ХХК аудитор: С.Цэрэнминжин Утас: 99458717 Цахим хаяг: enhee_ja@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400. Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17.
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.БУЯНТӨР
ТАНАА

2022.02.25 № 14А - 2022/25/НА - САА-ТЧЗ
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200200467

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,785,520.00	2,943,300.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	22,700.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	22,700.00
3121	Төгрөг	00.00	22,700.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	22,700.00
33	АВЛАГА	44,920.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	44,920.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,740,600.00	2,920,600.00
354	Хангамжийн материал	1,740,600.00	2,920,600.00
35470	Бусад хангамжийн материал	1,740,600.00	2,920,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,403,338.76	4,566,678.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,403,338.76	4,566,678.82
392	Биет хөрөнгө	6,403,338.76	4,566,678.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,585,800.00	9,330,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,165,294.88	-6,708,954.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,619,473.00	14,839,473.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,636,639.36	-12,894,639.32
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,188,858.76	7,509,978.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	280,816.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	280,816.00
413	Өглөг	00.00	280,816.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	280,816.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,188,858.76	7,229,162.82
51	Засгийн газрын хувь оролцоо	8,188,858.76	7,229,162.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,306,100.00	1,306,100.00
51101	Өмч: - төрийн	1,306,100.00	1,306,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	6,851,713.76	5,892,017.82
51210	Өмнөх үеийн үр дүн	6,851,713.76	6,851,713.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-959,695.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	31,045.00	31,045.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,188,858.76	7,509,978.82

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,744,259.00	71,295,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,744,259.00	71,295,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,744,259.00	70,480,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,744,259.00	70,480,200.00

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	61,690,613.89	72,254,895.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,690,613.89	72,254,895.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,067,400.89	63,863,191.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,743,593.00	48,905,621.33
210101	Үндсэн цалин	36,190,593.00	41,107,360.33
210104	Урамшуулал	12,553,000.00	7,798,261.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,587,000.00	6,302,122.00
210201	Тэтгэврийн даатгал	4,635,300.00	4,349,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	487,900.00	488,144.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	390,300.00	390,515.00
210204	Ажилгүйдлийн даатгал	103,500.00	97,630.00
210205	Эрүүд мэндийн даатгал	970,000.00	976,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,403,233.00	2,383,288.00
210401	Бичиг хэрэг	707,800.00	482,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,401,200.00	1,779,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,233.00	121,688.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,000.00	
210408	Бараа материал акталсны зардал	25,000.00	
2107	Томилолт, зочны зардал	330,000.00	707,000.00
210702	Дотоод албан томилолт	330,000.00	707,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,000.00	214,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,813,574.89	5,351,159.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,518,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	757,900.00	1,636,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,055,674.89	2,196,659.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	623,213.00	8,391,704.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	6,478,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	165,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	423,213.00	1,913,504.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	423,213.00	1,913,504.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-946,354.89	-959,695.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-946,354.89	-959,695.94

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	60,744,259.00	71,295,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,744,259.00	71,295,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,744,259.00	70,480,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,744,259.00	70,480,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	60,744,259.00	71,272,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,744,259.00	71,272,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,121,046.00	62,880,795.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,788,513.00	48,423,612.00
210101	Үндсэн цалин	36,235,513.00	35,870,612.00
210104	Урамшуулал	12,553,000.00	12,553,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,587,000.00	6,458,395.33
210201	Тэтгэврийн даатгал	4,635,300.00	4,506,698.13
210202	Тэтгэмжийн даатгал	487,900.00	487,899.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	390,300.00	390,299.04
210204	Ажилгүйдлийн даатгал	103,500.00	97,599.51
210205	Эрүүл мэндийн даатгал	970,000.00	975,899.10
2104	Хангамж, бараа материалын зардал	2,577,733.00	2,202,038.00
210401	Бичиг хэрэг	688,300.00	482,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,401,200.00	1,597,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,233.00	121,688.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	249,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	889,900.00	360,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	889,900.00	360,000.00
2107	Томилолт, зочны зардал	270,000.00	707,000.00
210702	Дотоод албан томилолт	270,000.00	707,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,000.00	214,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	817,900.00	4,515,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,879,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	817,900.00	1,636,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	623,213.00	8,391,704.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	6,478,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	165,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	423,213.00	1,913,504.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	423,213.00	1,913,504.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	22,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	22,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	22,700.00

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,306,100.00	31,045.00	7,798,071.65	9,135,213.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-946,354.89	-946,354.89
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,306,100.00	31,045.00	6,851,713.76	8,188,858.76
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,306,100.00	31,045.00	6,851,713.76	8,188,858.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,306,100.00	31,045.00	6,851,713.76	8,188,858.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-959,695.94	-959,695.94
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,306,100.00	31,045.00	5,892,017.82	7,229,162.82

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,032,500.00	65,537,607.30	4,494,892.7	93.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,032,500.00	65,537,607.30	4,494,892.7	93.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,252,700.00	59,119,407.30	4,133,292.7	93.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,912,500.00	38,157,349.00	755,151.0	98.1%
210101	Үндсэн цалин	31,380,700.00	30,756,544.00	624,156.0	98.0%
210104	Урамшуулал	7,531,800.00	7,400,805.00	130,995.0	98.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,253,200.00	5,018,758.30	234,441.7	95.5%
210201	Тэтгэврийн даатгал	3,696,700.00	3,503,099.51	193,600.5	94.8%

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	389,100.00	389,270.84	-170.8	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	311,300.00	311,416.62	-116.6	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	77,900.00	74,088.35	3,811.6	95.1%
210205	Эрүүл мэндийн даатгал	778,200.00	740,882.98	37,317.0	95.2%
2104	Хангамж, бараа материалын зардал	6,783,400.00	6,783,400.00	0.0	100.0%
210401	Бичиг хэрэг	621,800.00	616,300.00	5,500.0	99.1%
210402	Тээвэр, шатахуун	6,090,200.00	6,098,100.00	-7,900.0	100.1%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	71,400.00	69,000.00	2,400.0	96.6%
2107	Томиллолт, зочны зардал	720,400.00	695,000.00	25,400.0	96.5%
210702	Дотоод албан томилолт	720,400.00	695,000.00	25,400.0	96.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	482,800.00	216,000.00	266,800.0	44.7%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00	0.0	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,400.00		49,400.0	0.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,000.00		24,000.0	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11100400.00	8248900.00	2,851,500.0	74.3%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,321,400.00	3,870,400.00	1,451,000.0	72.7%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,779,000.00	4,378,500.00	1,400,500.0	75.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6779800.00	6418200.00	361,600.0	94.7%
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,779,800.00	6,418,200.00	361,600.0	94.7%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	6,313,200.00	0.0	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	466,600.00	105,000.00	361,600.0	22.5%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,032,500.00	65,537,607.30	4,494,892.7	93.6%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,260,100.00	65,537,607.30	-5,277,507.3	108.8%
132001	Орон нутгийн төсвөөс	60,260,100.00	65,537,607.30	-5,277,507.3	108.8%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,772,400.00		9,772,400.0	0.0%
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	9,772,400.00		9,772,400.0	0.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5	0.0	100.0%
620001	Удирдах ажилтан	1	1	0.0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1	0.0	100.0%
620004	Гэрээт ажилтан	3	3	0.0	100.0%

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815,000.00	815,000.00	0.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,000.00	815,000.00	0.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ				
2104	Хангамж, бараа материалын зардал				
210401	Бичиг хэрэг				
210402	Тээвэр, шатахуун				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210604	Урсгал засвар				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	815,000.00	815,000.00	0.00	0.00
2109	раа үйлчилгээний бусад зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	815,000.00	815,000.00	0.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	815,000.00	815,000.00	0.00	0.00
31	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	815,000.00	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт өрсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 61,690.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,233.8 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 72,254.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,445.1 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцох хувийг 80 хувиар тооцож 1,156.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,836.6 мянган төгрөгөөр буюу 28.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс, бараа материал, авлага, өр төлбөр данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	22,700.00	22,700.00
Авлага	44,920.00	00.00	-44,920.00
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	1,740,600.00	2,920,600.00	1,180,000.00
Үндсэн хөрөнгө	6,403,338.76	4,566,678.82	-1,836,659.94
Нийт хөрөнгө	8,188,858.76	7,509,978.82	-678,879.94
Өр төлбөр	00.00	280,816.00	280,816.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,188,858.76	7,229,162.82	-959,695.94
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,188,858.76	7,509,978.82	-678,879.94

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн данс 22.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 44.9 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,920.6 мянган төгрөг болж 1,180.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан хангамжийн материалаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын нэмэгдсэн нь байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,566.6 мянган төгрөг болж 1,836.6 мянган төгрөгөөр буурсан нь актлагдсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 280.8 мянган төгрөг болж нэмэгдсэн нь хувь хүний орлогын албан татварын өглөгөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,206.4 мянган төгрөг болж 982.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 13,958.2 мянган төгрөгөөр буюу 24.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 10,586.9 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн байна. Үүнд цалин, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна. Өмнөх онтой харьцуулахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал шинээр төлөвлөсөн, албан хаагч нэг удаагийн тэтгэмжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 70,480.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 76,850.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 6,370.0 мянган төгрөгөөр бууруулж 70,480.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин болон бусад зардалд төлөвлөсөн зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 70,480.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 70,480.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 70,480.2 мянган, дээд шатны байгууллагаас 815.0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 71,295.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 69,359.0 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 815.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр өгсөн байна.

Үүнээс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 815.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан гэж байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгсөн байсан тул Шилэн дансны сайтад байршуулсан мэдээллийг хянаж баталгаажууллаа.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 87, хугацаа хоцроож 30, хугацаа болоогүй 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулахаас Цагдаагийн хэсгийн урсгал зардалд хөрөнгө зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг авч ажиллаж 1,913.5 мянган төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах гэсэн зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,214.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,913.5 мянган төгрөгийн алдааг залруулж, зориулалт бусаар зарцуулсан 120.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага, 181.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Үүнд:

4.1 Залруулсан алдаа

1. Төвлөрүүлэх шилжүүлгийн 1,913.5 мянган төгрөгийн зардлыг үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээгээр тайлагнасан байсныг залруулга хийлгэсэн.

4.2 Албан шаардлага

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас цагдаагийн хэсгийн интернэтийн төлбөрт 120.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн.

4.3 Зөвлөмж

1. *Зардалтай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас замын хуудасгүйгээр 181.2 мянган төгрөгийн шатах тослох материалыг зарцуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

1. Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах.
2. Цагдаагийн хэсгийн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулахыг таслан зогсоох.

Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас зарцуулсан шатах тослох материалыг замын хуудас, ажлын тайлан бичиж баримтжуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	2,214.7	1	1,913.5			1	120.0	1	181.2


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТСУУРЫ/

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР
АУДИТОР

/С.ЦЭРЭНМИНЖИН/

2022 оны 2-р сарын 18-ний өдөр